ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ, МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
2018 ОНД ХАМТРАН АЖИЛЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2018.12.10

| № | Бүтээгдэхүүний нэр төрөл | Хугацаа | Биелэлт | Хувь |
|---|---|---|---|---|
| **А.Хяналт шалгалт** | | | | |
| **1. Автотээвэр** | | | | |
| 1 | “АТҮТ” ТӨҮГ-ын тээврийн хэрэгслийн бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх /УБ хот/ | I улиралд | Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн 88 дугаар тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэг “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын үйл ажиллагаанд шалгалт хийх үед тээврийн хэрэгслийн бүртгэлийн хэлтэсийн үйл ажиллагааг шалгасан. | 100% |
| 2 | Нийслэлийн тээврийн газрын “Техникийн хяналтын үзлэгийн төв”-д шалгалт хийх | II улиралд | Төрийн нарийн бичгийн даргын баталсан 38-07-003,076/41 дугаартай удирдамжийн дагуу 2018.09.13-14-ний өдрүүдэд Нийслэлийн тээврийн газрын Техникийн хяналтын үзлэгийн төвийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт хяналт шалгалт хийж, 38-07-003,076/50 дугаартай улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлсэн. Гүйцэтгэлийн шалгалт 2019 онд хийнэ. Шалгалтад НМХГ-аас оролцоогүй | 100% |
| 3 | Өмнөговь аймгийн Тавантолгой нүүрсний уурхай, Дорноговь аймгийн Ханги боомтоор улс хоорондын ачаа тээвэрлэгч байгууллагуудад хяналт шалгалт хийж, эрсдэл тогтоох | III улиралд | Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Р.Мэргэнийн 2018 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 38-07-002/51 дугаартай удирдамжийн дагуу Дорноговь аймгийн Мандах, Хөвсгөл, Хатанбулаг сумын нутагт орших уурхай болон Ханги хийлийн боомтод улс хоорондын ачаа тээвэр эрхлэгч аж ахуйн нэгжид МХЕГ, “АТҮТ” ТӨҮГ, аймгийн МХГ, Автотээврийн төвийн автотээврийн хяналтын улсын байцаагч нар хамтран шалгалт хийсэн. Шалгалтад хамрагдсан нийт 39 байгууллагуудаас 11 байгууллагын үйл ажиллагааг хяналтын хуудсаар шалгаж, улсын байцаагчийн албан шаардлага болон Дорноговь аймгийн МХГ, Автотээврийн төвийн автотээврийн хяналтын улсын байцаагч нар 6,5 сая төгрөгийн шийтгэлийн арга хэмжээ авч, шалгах боломжгүй болон “Улс хоорондын автотээврийн ачаа, зорчигч тээвэрлэлт. Тээвэрлэлтийн ерөнхий шаардлага” MNS 5831:2007 улсын стандартын шаардлагыг хангахгүй 28 аж ахуйн нэгжийн улс хооронд тээвэрлэлт хийх “С” төрлийн бичгийг түр зогсоох талаар | 100% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | “АТҮТ” ТӨҮГ-т үүрэг өгч ажилласан. | |
| 4 | Хүнсний түргэн гэмтэх, эмзэг бүтээгдэхүүн тээвэрлэгч иргэд, байгууллагуудад Улаанбаатар хотын хяналтын 4 цэгт, орон нутгийн хяналтын цэгүүд болон шугам замд шалгалт хийх | II улиралд | “Хүнсний түргэн муудах, эмзэг бүтээгдэхүүнийг тээвэрлэх” үйл ажиллагаанд Замын цагдаагийн алба, Нийслэлийн авто замын хөгжлийн газар, НТГ, “АТҮТ” ТӨҮГ-тай хамтран шугам замын хяналт шалгалт хийсэн байна. Нийслэлийн хэмжээнд: 13 удаагийн шалгалт хийж, ачаа тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхэлж байсан 458 иргэн хамрагдаж, зөрчил гаргасан 230 иргэнд 21.770.0 мянган төгрөгийн шийтгэлийн арга хэмжээ ногдуулж ажилласан байна. Шалгалтад Хархорин, Баянзүрх, Хүчит шонхор зэрэг томоохон худалдааны төвүүд рүү чиглэсэн хүнсний түргэн муудах эмзэг бүтээгдэхүүн тээвэрлэдэг иргэд болон “Сүү” ХК, “Хаан хүнс” трейд, “Тэсо” трейд, “Талх чихэр” ХК, “Атар өргөө” ХК зэрэг аж ахуйн нэгж байгууллагын нийт 230 тээврийн хэрэгсэл хамрагдсан байна. Шалгалтад хамрагдсан байгууллагуудын эрсдэлийг үнэлэхэд “Сүү” ХК-7.7%-тай, “Хаан хүнс” трейд 23%-тай “бага эрсдэлтэй” гэж дүгнэгдсэн байна. | 100% |
| 5 | “АТҮТ” ТӨҮГ-ын Баян-Өлгий аймаг дахь Автотээврийн төвийн техникийн хяналтын үйл ажиллагаа, хот хоорондын нийтийн зорчигч тээвэр эрхлэгч “Цэнгэл транс” ХХК-д шалгалт хийх | II улиралд | Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 38-07-003/08 дугаартай удирдамжийн дагуу Баян-Өлгий, Ховд аймгийн Автотээврийн төвүүд, хот хоорондын нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд 2018 оны 4 дүгээр сарын 02-07-ны өдрүүдэд төлөвлөгөөт шалгалтыг хийсэн.<br>Шалгалтын явцад Баян-Өлгий аймгийн Автотээврийн төв/36/, “Цэнгэл транс” ХХК/18/, “Аумин” ХХК/17/-д нийт 71 зөрчлийг илрүүлж, Баян-Өлгий аймгийн Автотээврийн төвд 300.0 мян.төг, “Цэнгэл транс” ХХК-д 1,500.0 мян.төг нийт 1,800.0 мян.төг-ийн шийтгэлийн арга хэмжээ авсан.<br>Түүнчлэн, Баян-Өлгий аймгийн Автотээврийн төвийн “Техникийн хяналтын үзлэгийн төвийн үйл ажиллагааг зогсоох тухай” 01-111/04-07-037/09/09 дугаар улсын ахлах байцаагчийн акт, “Цэнгэл транс” ХХК/07-111/36/-д “Хууль тогтоомж, стандарт, дүрэм, журмын шаардлага хангуулах тухай” улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлсэн. | 100% |
| | | | **2. Авто зам** | |
| 1 | Он дамжин хэрэгжиж буй болон шинээр баригдаж эхлэх авто зам, замын | | -Өлгий-Ховд чиглэлийн 189.7 км хатуу хучилттай авто зам-75%-тай ба багц1-50 км, багц1,2-56,6 км хатуу хучилттай | 100% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | байгууламжийн барилга угсралт, засвар шинэчлэлтийн ажилд хамтарсан хяналт шалгалт хийх. Үүнд:<br>-Өлгий-Ховд чиглэлийн 189.7 км хатуу хучилттай авто зам;<br>-Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн 67 км хатуу хучилттай авто зам;<br>-Ховд-Булган-Үенч чиглэлийн 60 км хатуу хучилттай авто зам;<br>-Аймгийн төвийн хатуу хучилттай авто замын шинэчлэлт 4.5 км хатуу хучилттай авто зам /Баян-Өлгий аймаг, Өлгий сум/;<br>-Аймгийн төвийн хатуу хучилттай авто замын шинэчлэлт 4.312 км хатуу хучилттай авто зам /Ховд аймаг, Жаргалант сум/;<br>-Сонгино-Хяргас нуурын зүүн хаяа чиглэлийн 135.5 км хатуу хучилттай авто зам;<br>-Тосонцэнгэлийн 4 замын уулзвар Нөмрөг - Сонгино чиглэлийн 167 км хатуу хучилттай авто зам.<br>-Ханх-Монд чиглэлийн 22.172 км хатуу хучилттай авто зам; | II-IV улиралд | авто замыг байнгын ашиглалтад оруулж байна.<br>Сонгино-Хяргас нуурын зүүн хаяа чиглэлийн 135.5 км хатуу хучилттай авто зам-62% буюу 83,4 км км хатуу хучилттай авто замыг байнгын ашиглалтад оруулж байна.<br><br>Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн 67 км хатуу хучилттай авто зам;-60%<br>Ховд-Булган-Үенч чиглэлийн 60 км хатуу хучилттай авто зам-99%<br>Аймгийн төвийн хатуу хучилттай авто замын шинэчлэлт 4.5 км хатуу хучилттай авто зам /Баян-Өлгий аймаг, Өлгий сум/;<br>-Аймгийн төвийн хатуу хучилттай авто замын шинэчлэлт 4.312 км хатуу хучилттай авто зам /Ховд аймаг, Жаргалант сум/;<br>-Ханх-Монд чиглэлийн 23 км хатуу хучилттай авто замуудыг байнгын ашиглалтад оруулсан.<br>Тосонцэнгэлийн 4 замын уулзвар Нөмрөг - Сонгино чиглэлийн 167 км хатуу хучилттай авто замд хяналт тавьсан ба барилгын ажил 14%-тай | |
| 2 | БНХАУ-ын ЗГ-аас МУ-ын ЗГ-т олгох хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр Улаанбаатар хотод баригдах:<br>-Яармагийн шинэ гүүр барих, хуучин гүүрийн засварлах төсөл,<br>-Туул гол дээрх Баянзүрхийн 288 у.м гүүр,<br>-Сонсголонгийн 289.4 у.м төмөр бетон гүүрийн шинээр барих төсөл,<br>-Замын цагдаагийн газрын ойролцоох гүүрэн гарц барих төсөл. | II-IV улиралд | БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр Улаанбаатар хотод баригдаж байгаа Яармагийн шинэ гүүр барих, хуучин гүүр засварлах төслийн барилгын ажлын явцад МХЕГ-ын даргын баталсан 2018.05.01-ний өдрийн 02/150 дугаартай удирдамжийн дагуу 2018.05.03-11-ний хооронд хяналт шалгалт хийж гүйцэтгэсэн. Шалгалтын явцад 15 зөрчил илрүүлж, улсын ахлах байцаагчийн 07/096/124 дугаартай албан шаардлага хүргүүлсэн. Туул гол дээрх Баянзүрхийн 288 у.м гүүр,<br>-Сонсголонгийн 289.4 у.м төмөр бетон гүүрийн шинээр барих төсөл,<br>-Замын цагдаагийн газрын ойролцоох гүүрэн гарц барих төсөлд хяналт тавьж ажилласан ба барилгын ажил 2019 онд үргэлжилнэ. | 100% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 3 | Улсын чанартай зам, замын байгууламжийн байнгын бэлэн байдал, ашиглалтын бэлэн байдлын түвшинд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх. /Зам хариуцагч ТӨХК 20, хувийн хэвшлийн 8 аж ахуйн нэгж хамрагдана/. | I-III улиралд | Төрийн нарийн бичгийн даргын баталсан 2018.06.08-ны өдрийн 38-07-09-01/23 дугаартай удирдамжийн дагуу Зам хариуцагч ТӨХК 20, хувийн хэвшлийн 8 аж ахуйн нэгжийн улсын чанартай зам, замын байгууламжийн байнгын бэлэн байдал, ашиглалтын бэлэн байдлын түвшинд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт | 100% |
| 3 | Үргэлжилж байгаа барилга байгууламжид гүйцэтгэлийн шалгалт хийх:<br>-Улаанбаатар-Хөшигийн хөндийн ОУШНОБ чиглэлийн 32 км хатуу хучилттай авто зам;<br>-Баянхонгор-Байдрагийн гүүр чиглэлийн 129.4 км хатуу хучилттай авто зам;<br>-Улиастай-Тосонцэнгэл чиглэлийн 114 км хатуу хучилттай авто зам;<br>-Ханх-Монд чиглэлийн 22.172 км хатуу хучилттай авто зам;<br>-Ховд аймгийн Хөшөөтийн уурхайгаас Ярантын боомт чиглэлийн 315 км хатуу хучилттай авто замын ашиглалт, засвар арчлалт | I-IV улиралд | МХЕГ-ын даргын баталсан 2018.05.03-ны өдрийн 01/155 дугаартай удирдамжийн дагуу Улаанбаатар-Хөшигийн хөндийн ОУШНОБ чиглэлийн 32 км хатуу хучилттай авто замын барилгын ажлын явцад ЗТХЯ, МХЕГ, НМХГ-тай хамтран 2018.05.07-17-ны хооронд хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн.<br>Гүйцэтгэгч 2 байгууллагад улсын ахлах байцаагчийн 2018.06.06-ны өдрийн 07/096/124-125 дугаартай албан шаардлага хүргүүлсэн. Барилгын ажил-96,2%-тай;<br>Баянхонгор-Байдрагийн гүүр чиглэлийн 129.4 км хатуу хучилттай авто зам-88,6%-тай<br>-Улиастай-Тосонцэнгэл чиглэлийн 114 км хатуу хучилттай авто зам-99.4%-тай хяналт тавин ажиллаж байна.<br>-Ханх-Монд чиглэлийн 22.172 км хатуу хучилттай авто замыг байнгын ашиглалтад оруулсан. | 100% |
| **3.Төмөр зам** | | | | |
| 1 | "УБТЗ" ХНН-ийн Дархан, Толгойт, Улаанбаатар, Амгалан өртөөнд төмөр замын зурвас газар, аюултай бүсэд зөвшөөрөлгүй газар олгосон асуудлыг хамтран шалгах. | I-II улиралд | Тус яамны 2018.05.10-ны өдрийн 10а/2064 тоот албан бичгээр МХЕГ-т хүргүүлсэн ЗТХЯ болон МХЕГ-ын 2018 онд хамтран ажиллах ажлын төлөвлөгөөний дагуу төмөр замын зурвас газар, аюултай бүсэд зөвшөөрөлгүй газар олгосон асуудлыг хянан шалгах ажлыг 2018 оны 12 дугаар сарын 05-ны өдөр МХЕГ-ын Дэд бүтцийн хяналтын газрын даргатай 2018 оны хамтарч хийх ажлын үр дүнг хэлэлцэх хурлын шийдвэрээр 2019 оны төлөвлөгөөнд шилжүүлэхээр шийдвэрлэсэн. | 0 |
| 2 | “МТЗ” ТӨХК-ийн Төмөртэй өртөөнд холбоо, дохиололын чиглэлээр хамтарсан хяналт шалгалт хийх. | III-IV улиралд | “Монголын төмөр зам” ТӨХК-ийн Төмөртэй өртөөнд ЗТХЯ-ны ТНБДҮТОГ-ийн 2018 оны 10 дугаар сарын 17-ны өдөр баталсан 38-07-020/53 дугаар удирдамжийн хүрээнд 2018.10.25, 26-ны өдрүүдэд МХЕГ-ын ДБХ-ын газрын Харилцаа холбооны хяналтын улсын ахлах байцаагч Б.Бүрэнжаргалын хамт хяналт шалгалтыг хийж гүйцэтгэн улсын ахлах байцаагчийн албан шаардлага хүргүүлсэн. | 100% |
| **4. Усан зам** | | | | |
| 1 | Монгол Улсын “Усан замын тээврийн | 6-7 | Далайн захиргааны даргын 2018 оны 06 дугаар тушаалаар | 100% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | тухай” хуульд заасанаар усан замын тээврийн хэрэгслийн ээлжит техникийн хяналтын үзлэг, тооллого, шалгалтыг Ховд, Увс, Завхан, Сэлэнгэ, Булган, Төв, Хэнтий, Өвөрхангай аймгуудын хэмжээнд зохион байгуулж явуулах | дугаар саруудад | 2018 оны Усан замын тээврийн хэрэгслийн үзлэг, тооллогын ажлыг 2018.06.15-ны өдрөөс 08 дугаар сарын 01-ний өдрүүдэд улсын хэмжээнд зохион байгуулах ажлын хэсгийг байгуулсан. Бэлтгэл ажил хангагдсан. Орон нутгийн радио, телевизээр мэдээлэл хүргэх ажлыг зохион байгуулсан | |
| 2 | Нуур, гол мөрөн хөлдөх, гэсэх үеэр ард иргэдийг техник хэрэгслээр мөсөн дээгүүр зорчуулахгүй байлгах, зорчих зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд аюулгүй байдлыг зохих ёсоор хангуулж, зорчуулах тухай албан бичгийг тухайн нуур, гол, мөрнийг нутаг дэвсгэртээ харьяалж буй аймаг, орон нутгийн удирдлагад хүргүүлж хэрэгжилтэд хяналт тавих. | 1-4 дүгээр саруудад | Мөсөн замаар зорчигч тээвэр, тээврийн хэрэгсэл бүхий иргэдэд учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор Хөвсгөл аймгийн Ханх сумын Засаг даргын 2018 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А01 дугаар захирамж гаргуулан мөсөн замаар тээврийн хэрэгслээр зорчихыг хориглон нийт ард иргэд, зорчигч тээврийн үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагад хориглосон шийдвэрийг сурталчлан таниулж, гарын үсэг зуруулж ажиллав. | 100% |
| 3 | Жил бүр аялал жуулчлалын зорилгоор уламжлал болгон зохиогддог “Мөсний баяр”-ын үеэр түүнд оролцогчдын аюулгүй байдлыг хангахад хяналт тавих, /мөсний баяр зохиогдох газрыг сонгох, тээврийн хэрэгсэл зорчих зам болон аялагчдын явах маршрутыг тогтоох, түүнд тэмдэг тэмдэглэгээ хийх, мөн аюултай бүсийг тогтоож анхааруулах тэмдэг, дарцагжуулах г.м/ оролцох | 3 дугаар сард | Хөвсгөл аймгийн ЗДТГ, Онцгой байдлын газар болон Мэргэжлийн хяналтын газартай хамтран “Мөсний баяр”-ын үеэр 2018.03.02-04-ний өдрүүдэд иргэдийн аюулгүй байдлыг хангахад хяналт тавин ажилласан ба тэмдэг тэмдэглэгээ, анхааруулах тэмдэг, дарцагжуулах ажил зохион байгуулсан. | 100% |
| 4 | Хөвсгөл аймгийн Ханх сум, Хатгал тосгонд усан замын тээврийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад тээвэрлэлтийн аюулгүй ажиллагаанд хяналт тавих, заавар, зөвлөмжөөр ханган ажиллах | 6-10 дугаар саруудад | Усан замын тээврийн үйлчилгээ эхлэх тухай Хөвсгөл аймгийн Засаг даргын 2018.06.07-ны өдрийн захирамжийн дагуу 2018.06.08-ны өдрөөс усан замын тээврийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 138 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад тээвэрлэлтийн аюулгүй ажиллагаанд хяналт тавьж, мэргэжил арга зүйн зөвлөгөөг өгч ажилласан | 100% |
| 5 | Усан замын тээврийн хэрэгслийн тээвэрлэлтийн болон техник ашиглалтын байдалд хяналт шалгалт хийх /Хөвсгөл аймгийн Хатгал тосгон, Ханх сум/ | 6-10 дугаар сард | Төрийн нарийн бичгийн даргын баталсан 38-07-054/32 дугаартай удирдамжийн дагуу Хөвсгөл аймгийн Хатгал тосгон, Ханх суманд усан замын тээврийн хэрэгслийн тээвэрлэлтийн болон техник ашиглалтын байдалд Монгол Улсын Далайн захиргаатай хамтран 2018.07-08 сард хянал шалгалт хийж, 6 аж ахуйн нэгж, 2 иргэнд улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлсэн | 100% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **Б.Хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох** | | | | |
| 1 | Зам, тээврийн салбарын эрх зүйн орчинг сайжруулах талаар холбогдон гарах хууль, дүрэм, журам, стандарт, хөтөлбөр, төсөлд санал боловсруулах | I-IV улиралд | Зам, тээврийн салбарын эрх зүйн орчинг сайжруулах талаар дараах хууль, дүрэм, журам, стандартын төсөлд санал өгсөн. Үүнд:<br><br>1. Автотээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл;<br>2. Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл;<br>3. Авто зам, замын байгууламжийн барилгын ажлыг эхлүүлэн, үргэлжлүүлэн, ашиглалтад оруулах журам;<br>4. Авто зам, замын байгууламжийн Техник-эдийн засгийн үндэслэл, Зураг төсөл боловсруулах, барих, арчлах, засварлах, Техник технологийн хяналт тавих зөвлөх үйлчилгээ үзүүлэх ажлын тусгай зөвшөөрөл олгох журам,<br>5. Тусгай зориулалтын авто зам, замын байгууламж барих, ашиглах журам,<br>6. Авто замын салбарын мэргэжилтэй ажилтан бэлтгэх, давтан сургах журам,<br>7. Авто зам, замын байгууламжийн зураг төсөлд магадлал хийж, дүгнэлт гаргах журам,<br>8. Авто замын ашиглалтын бэлэн байдлын түвшингээр санхүүжүүлэх журам,<br>9. Авто замын байгууламжийг хаах, чиглэл өөрчлөх, тээврийн хэрэгслийн тэнхлэгийн даацад хязгаарлалт хийх журам;<br>10. Төмөр замын техник ашиглалтын журам;<br>11. Төмөр замын дохиолол холбооны журам;<br>12. Галт тэрэгний хөдөлгөөний удирдлагын журам;<br>13. Төмөр замын тээвэр дэх осол, гологдлыг судлан бүртгэх журам;<br>14. Төмөр замаар ачаа тээвэрлэх журам;<br>15. Төмөр замаар зорчигч, тээш, ачаан тээш тээвэрлэх журам;<br>16. Төмөр замын тээвэр зуучлалын үйл ажиллагааны журам;<br>17. Галт тэрэгний зурмаг зохицуулалтын журам;<br>18. Суурь бүтэц ашиглуулах журам, тариф тогтоох | 100% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | аргачлал;<br>19. Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой зарим объект, үйл ажиллагаанд гэрчилгээ олгох журам;<br>20. Төмөр замын аюултай бүс, төмөр замын зурвас газар, аюулгүйн бүсэд төмөр замын болон бусад объект байрлуулах, үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах, нэвтрэх журам;<br>21. Монгол Улсын хилээр нэвтэрч буй хөдлөх бүрэлдэхүүний бүртгэл хөтлөх, хүлээлцэх журам;<br>22. Галт тэрэгний хөдөлгөөнтэй шууд холбоотой ажилтны сахилгын тусгай журам, ажлын цагийн хуваарь, хөдөлмөрийн нөхцөл;<br>23. Төмөр замын мэргэжилтэй ажилтныг бэлтгэх, сургалт явуулах, мэргэжлийн шалгалт авах журам;<br>24. Суурь бүтэц, нийтийн болон дагнасан хэрэглээний зам ашиглах, суурь бүтэц эзэмшигч, тээвэрлэгч хоорондын хамтран ажиллах болон тээвэрлэлтийн үйлчилгээ үзүүлэх гэрээний үлгэрчилсэн загвар;<br>25. Төмөр замын байгууллагууд харилцан мэдээлэл солилцох журам төсөл зэрэг байна. | |
| 2 | Төмөр замын тээврийн хяналтын шалгуур үзүүлэлтийг боловсруулах, холбогдох эрх бүхий байгууллагад танилцуулах. | II-IV улиралд | 2018 оны 12 дугаар сарын 05-ны өдөр МХЕГ-ын Дэд бүтцийн хяналтын газрын даргатай 2018 онд хамтарч хийх ажлын үр дүнг хэлэлцэх хурлын шийдвэрээр 2019 оны төлөвлөгөөнд шилжүүлэхээр шийдвэрлэсэн. | 0 |
| **В. Байгууллага, иргэдэд зориулсан сургалт семинар, зөвлөн туслах, урьдчилан сэргийлэх ажил, тандалт судалгааг зохион байгуулах** | | | | |
| 1 | Төмөр замын тээврийн хяналтын шалгуур үзүүлэлтийг боловсруулахтай холбогдуулан төмөр замын тээврийн үйл ажиллагаанд тандалт судалгаа хийх. | I улиралд | 2018 оны 12 дугаар сарын 05-ны өдөр МХЕГ-ын Дэд бүтцийн хяналтын газрын даргатай 2018 онд хамтарч хийх ажлын үр дүнг хэлэлцэх хурлын шийдвэрээр 2019 оны төлөвлөгөөнд шилжүүлэхээр шийдвэрлэсэн. | 0 |
| 2 | Улсын чанартай зам, замын байгууламжийн байнгын бэлэн байдал, ашиглалтын төвшин хангуулах, зам хариуцагч байгууллагуудад мэргэжлийн болон хууль эрх зүйн “зөвлөн туслах үйлчилгээ”-г үзүүлэх | I-III улиралд | Төрийн нарийн бичгийн даргын баталсан 2018.06.07-ны өдрийн 38-07-09-01/24 дугаар удирдамжийн дагуу Өвөрхангай АЗЗА ТӨХК-ийн санхүү, үйл ажиллагаанд 2018 оны 06 дугаар сарын 11-ний өдрөөс 06 дугаар сарын 13-ны өдрүүдэд шалгалт хийлээ. Санхүүгийн хяналтын улсын ахлах байцаагч, авто замын хяналтын улсын байцаагч нарын хамтарсан зөвлөмжийг хүргүүлсэн | 100% |
| 3 | Ховд аймгийн Хөшөөтийн нүүрсний | III | Төрийн нарийн бичгийн даргын баталсан удирдамжийн | 100% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | уурхайгаас улс хоорондын ачаа тээвэрлэгч байгууллагуудад зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх | улиралд | дагуу 2018.09.07-ны өдрөөс 14-ний хооронд Ховд аймгийн Хөшөөтийн нүүрсний уурхайгаас улс хоорондын ачаа тээвэрлэгч 19 байгууллагад зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн. | |
| 4 | Авто үйлчилгээ эрхлэгч иргэн, аж, ахуйн нэгж, байгууллагуудад зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх (Улаанбаатар хотод 100, орон нутагт 100) | II-III улиралд | ЗТХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын баталсан Зөвлөн туслах үйлчилгээний удирдамжийн дагуу 2018.09.24-10.02 өдрүүдэд орон нутгийн Авто үйлчилгээ(засвар) эрхлэгч 100 иргэн, аж ахуйн нэгжид зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн. Нийслэлийн тээврийн газрын хяналтын хэлтэстэй хамтран Улаанбаатар хотын засвар үйлчилгээ эрхлэгч 80 иргэн, байгууллагуудад 2018.10.15-10.19-ны өдрүүдэд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж, ажилласан | 100% |
| 5 | Хотын доторхи нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч байгууллагуудын автотээврийн хэрэгслийн ашиглалтын байдал, засвар үйлчилгээнд тандалт судалгаа хийх | I улиралд | Төрийн нарийн бичгийн даргын баталсан удирдамжийн дагуу Нийслэлийн тээврийн газартай хамтран 2018.04.18-наас 05 сарын 20-ны хооронд хотын доторхи 21, орон нутгийн ААН-ын автотээврийн хэрэгслийн ашиглалтын байдал, засвар үйлчилгээнд тандалт судалгаа хийсэн. Улаанбаатар хотын доторхи нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч 20 аж ахуйн нэгжид зөвлөмж хүргүүлсэн. | 100% |
| 6 | “АТҮТ” ТӨҮГ-ын Дорноговь аймгийн Замын-Үүд суман дахь салбар болон улс хоорондын зорчигч тээвэрлэгч “Дэлгэрэх тээх” ХХК-ийн үйл ажиллагаанд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх | I улиралд | “Осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх” ажлын хүрээнд Төрийн нарийн бичгийн даргын 2018-05-03-ны өдөр баталсан 38-07-003/19 дугаар удирдамжийн дагуу “Зөвлөн туслах үйлчилгээ”-г “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын Дорноговь аймгийн Замын-Үүд салбар, улс хоорондын зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэгч “Дэлгэрэх тээх” ХХК-ийн Дорноговь аймгийн Замын-Үүд дахь салбарт 2018 оны 05 дугаар сарын 07-11-ний хооронд үзүүлж, улсын ахлах байцаагчийн зөвлөмж хүргүүлсэн. | 100% |
| 7 | Хот хоорондын нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэгч “Тахилт хайрхан” ХХК/УБ/, “БСОД” ХХК/Шарын гол/-д зөвлөн туслах үйлчилгээ | III улиралд | ТНбД-ын баталсан удирдамжийн дагуу хот хоорондын нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэгч “БСОД” ХХК, “Шар зам ирээдүй” хоршооны үйл ажиллагаанд 2018 оны 10 дугаар сарын 22-29-ний өдрүүдэд зөвлөн туслах үйлчилгээг үзүүлж, “Тээвэрлэлтийн аюулгүй ажиллагааг хангаж ажиллах тухай” улсын байцаагчийн 2018 оны 11 дугаар сарын 01-ний өдрийн 38-07-003/45-46 дугаар бүхий зөвлөмжүүдийг хүргүүлсэн. “Тахилт транс” ХХК-ийн тээвэрлэлтийн гэрээ 2018 оны 3 сард цуцлагдсан. | 100% |
| 8 | Усан замын тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг, шалгалтад | 4-5 дугаар | 2018.06.12-ны өдрөөс 13-ны өдрүүдэд Хөвсгөл аймгийн Хатгал тосгонд Орон нутгийн мэргэжлийн хяналтын усан | 100% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | оролцох орон нутгийн мэргэжлийн хяналтын усан замын, байгаль орчны улсын байцаагч нарыг мэргэжил арга зүйн зөвлөмжөөр хангах ажлыг зохион байгуулах | саруудад | замын, байгаль орчны улсын байцаагч нарт “Усан замын тээврийн аюулгүй ажиллагаа” сэдэвт семинарыг зохион байгуулсан.<br>Семинарын үеэр усан замын тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг, шалгалтад оролцох орон нутгийн мэргэжлийн хяналтын усан замын, байгаль орчны улсын байцаагч нарт мэргэжил арга зүйн зөвлөмж өгч ажилласан зохион | |
| 9 | Хөвсгөл аймгийн Хатгал тосгонд “Усан замын тээврийн аюулгүй ажиллагаа” хамтарсан семинар зохион байгуулах | 6 дугаар сард | | 100% |
| 10 | Зам, тээврийн салбарын хяналтын улсын байцаагч нарыг мэргэшил дээшлүүлэх нэгдсэн сургалт зохион байгуулах | II улиралд | 2018 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр МХЕГ-аас зохион байгуулсан “Дэд бүтцийн хяналтын чиглэлийн хуулиар эрх олгогдсон улсын байцаагчдын сургалт”-д хамрагдсан.<br>МХЕГ-ын ДБХГ-ын даргын баталсан Улсын байцаагчдын сургалтын нэгдсэн хөтөлбөрийн дагуу Авто зам болон автотээврийн хяналтын улсын байцаагч нар 2018.06.04-07-ны өдрүүдэд сургалтад хамрагдсан. | 100% |
| 11 | Төмөр замын аюултай бүс, “Олон улсын гармын өдөрлөг”-ийг зохион байгуулах | II улиралд | “УБТЗ” ХНН-тэй хамтран Багахангай-Багануур хоорондын замын 40-р км-ийн гарам дээр 2018.06.07-нд “Олон улсын гармын өдөрлөг” зохион байгуулав. | 100% |

<u>Нийт төлөвлөгөөнд тусгагдсан 29 ажлаас 26 ажлыг хийж, төлөвлөгөөний биелэлт 89,6%-тай байна.</u>

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ